

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 65.020.40

Мод үржүүлгийн газар бордоо хэрэглэх

Compost and fertilizers for tree nursery

MNS 6252 : 2011

Стандартчилал, Хэмжил Зүйн Үндэсний Зөвлөлийн 2011 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 25 дугаар тогтоолоор батлав.

Энэ стандартыг улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн мөрдөнө.

1. Хамрах хүрээ

Энэ стандарт нь мод үржүүлгийн газар, мод сөөгний хөрсийг боловсруулах, үр тарих, суулгац үржүүлэхэд шаардагдах бордоог хэрэглэх арга, хэмжээг тодорхойлоход хамаарна.

2. Бордоог хөрсөнд хэрэглэх хэмжээ, арга

Мод үржүүлгийн газарт ургуулж байгаа ургамлыг бордох нь нэгж талбайгаас авах стандартын тарьц суулгацын гарцыг нэмэгдүүлэхэд чиглэсэн агротехникийн арга хэмжээ. Бордоо хэрэглэх хугацаа, тун хэмжээ хөрсний үржил шим, физик, химийн шинж чанараар тодорхойлогдоно. Шим бордоо хийх хэмжээг тооцохдоо үндсэндээ хөрсний механик бүтэц, түүний ялзмагийн агууламж, бордооны төрлийг тооцно.

2.1 Хөрсөнд агуулагдах эрдэс давс, азот, фосфор, кали хэмжээ болон хөрсний хүчиллэг шинж чанарыг агрохимийн шинжилгээгээр урьдчилан тодорхойлсны үндсэн дээр мод, сөөг ургамлын хэвийн өсөлт хөгжилтэд шаардагдах орон нутгийн ба эрдэс бордоог зохих хэмжээгээр нэмж өгнө.

2.2 Бордоог 1-р хүснэгтэд заасан шаардлагын дагуу хэрэглэнэ.

Бордоо хэрэглэх заавар

1-р хүснэгт

д/д	Бордооны нэр	Хэрэглэх хэмжээ, 1 га-д	Хийх арга хугацаа
1	Орон нутгийн бордоо	15-20 тн	Уринш хагалгааны өмнө цацна.
2	Бууцны шингэн	1:10 харьцаатай хольж	Мөр хооронд шүршиж хэрэглэнэ.
3	Ниймэл бордоо	20-40 тн	-Үр тарихын өмнө -Нэмэлт бордоог 6-р сарын эхээр 6-аас 8 см-т, мөн сарын сүүлд 10-аас 12 см-т мөр хооронд хийнэ.
4	Үнс	500-600 кг	Өглөө эрт хагалах газарт шороотой хольж жигд цацна.
5	Шувууны сангас	300-500 кг 1:10 харьцаатай усаар шингэлнэ.	Сийрүүлэлт ба борнойдолтын өмнө 2-оос 3 дахин их шороотой хольж хийнэ. Нэмэлт бордоонд ургамалд хүргэлгүй мөрний хооронд шүршиж хэрэглэнэ.
6	Эрдэс бордоо Азот: Навчт модонд Шилмүүст	20 кг 26-30 кг	Нэмэлт бордоонд

MNS 6252 : 2011

7	Фосфор: Ойт хээрийн бүсэд	70 кг	
8	Хээрийн бүсэд	60 кг	Шилмүүст модонд 30- 40% бага хэрэглэнэ

Тайлбар: а) Бууцны шингэн нь 1:3 харьцаатай усаар шингэлэн 1-ээс 2 хоноход бэлэн болно.
 б) Нийлмэл бордоог бэлтгэхдээ 7-оос 10-р сарын хооронд хуучин сүрэл, хог ургамлын иш, навч, модны үртэс зэргийг 1,5 м өндөр, 1,5 м өргөн овоолж шороогоор хучиж услана. Зуны турш 2-оос 3 удаа услаж, хутгаж өвөл шороо цасаар хучиж өвөлжүүлнэ. 2 жилийн дараа нийлмэл бордоо болно.
 в) Шувууны сангасыг нэмэлт бордоонд хэрэглэхдээ саванд 1:3 харьцаатай ус хийж, 1-ээс 2 хоног бэлтгэнэ.

2-р хүснэгт

Мод үржүүлгийн газрын хөрсөнд эрдэс бордоо хийх ТУН ХЭМЖЭЭ

Хөрсний категори /ялзмаг агууламжаар/	Ялзмагийн агууламж, %	Бордооны хэмжээ, кг/га		
		N	P	K
Элсэргэх хөрс				
Ядуу, хангалтгүй	3 хүртэл	40	40	40
Дунд ба сайн	3,01 ба их	25	30	25
Шавранцар хөрс				
Ядуу, хангалтгүй	3 хүртэл	60	70	45
Дунд ба сайн	3,01 ба их	60	60	50

Тайлбар: Сүүлийн тэжээлийг 8-р сарын дундаас хэтрүүлэлгүй явуулах ёстой. Бордоог хэтэрхий оройтуулж хийвэл ургамал ургалтын хугацааг сунгадаг.

Нарс, гацуурын тарьцанд тэжээл өгөх үеийн эрдэс бордооны хэмжээ

3-р хүснэгт

Тарьцын нас	Тэжээлийн №	Бордооны норм, кг/га					
		Нарс			Гацуур		
		N	P	K	N	P	K
Элсэнцэр хөрс							
1	1	30	-	-	20	-	-
	2	20	20	20	20	20	20
2	1	50	-	-	60	-	-
	2	50	40	40	40	40	40
3	1	60	-	-	60	-	-
	2	40	40	40	40	40	40
Шавранцар хөрс							
1	1	30	-	-	30	-	-
	2	30	45	30	30	45	30
2	1	30	45	30	30	45	30
	2	60	-	-	60	-	-
3	1	30	45	30	30	45	30
	2	60	-	-	60	-	-

7-р сард цухуйц гарах үед 1 настай тарьцанд тэжээлийг бүрэн бус байдлаар, ялзмагийн агууламж 3 %-иас илүү шавранцар хөрсөнд хийнэ. Ялзмагийн агууламж өндөртэй элсэнцэр хөрсөнд эхний бүрэн тэжээлийг 2 ба 3 настай тарьцанд, харин 2 дахийг зөвхөн азотоор бордоно.

Тэжээл хэлбэрээр эрдэс бордоо хийх тун хэмжээг бордоог хэрэглэж үзсний үндсэн дээр тогтооно.

ТӨГСӨВ.